



Ерөнхий Ассамблей

Түгээх: Ерөнхий
2014 оны 2 сарын 21
Албан бус орчуулга

Жараннаймдугаар чуулган

2013 оны 12 дугаар 18-ны өдрийн Ерөнхий Ассамблейн тогтоол

68/163. Сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хамгаалах, тэдний эсрэг гэмт үйлдэл ял шийтгэлгүй үлдэж буй асуудал

Ерөнхий Ассамблей нь,

Нэгдсэн Үндэстний Байгууллагын дүрмийн зорилт, зарчимыг удирдлага болгон,

Хүний эрхийн түгээмэл тунхаглалыг¹ дахин баталгаажуулж, хүний эрхийн олон улсын холбогдох гэрээ, тэр дундаа Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пакт², Хүнийг хүчээр сураггүй алга болгохын эсрэг олон улсын конвенц³, мөн 1949⁴ оны 8 дугаар сарын 12-ны өдөр батлагдсан Женевийн конвенц, түүний нэмэлт протоколыг⁵ эргэн санаж,

Нэгдсэн Үндэстний Байгууллагын системийн байгууллагуудын гүйцэтгэх захирлуудын хамтарсан зөвлөлийн 2012 оны 4 дүгээр сарын 12-ны өдөр баталсан дэлхийн хэмжээнд энх тайван, ардчилал, хөгжлийг бэхжүүлэх зорилгоор НҮБ-ын агентлаг, сан, хөтөлбөрийг зөрчил мөргөлдөөнт болон амар тайван нөхцлийн аль алинд буй сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтнуудад чөлөөтэй, аюулгүй орчин бүрдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагаанд Гишүүн улс орнуудтай хамтран ажиллахыг уриалан дуудсан “Сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хамгаалах, тэдний эсрэг гэмт үйлдэл ял шийтгэлгүй үлдэж буй асуудлаарх” НҮБ-ын үйл ажиллагааны төлөвлөгөөг эргэн санаж,

Хүний эрхийн зөвлөлийн интернэт дэх хүний эрхийг хөхиүлэн дэмжих, хамгаалан, хангах тухай 2012 оны 7 дугаар сарын 5-ны өдрийн 20/8 тоот,⁶ 2012 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн сэтгүүлчдийн аюулгүй байдлын тухай 21/12 тоот,⁷ 2013 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн Хүний эрхийн боловсролын

¹ Тогтоол 217 А (III).

² Тогтоол 2200 А (XXI), хавсралт.

³ Тогтоол 61/177, хавсралт.

⁴ НҮБ, *Гэрээний цуврал*, боть. 75, Nos. 970-973.

⁵ Мөн тэнд., боть. 1125, Nos. 17512 ба 17513.

⁶ *Ерөнхий Ассамблейн 67 дугаар чуулганы албан ёсны баримтаас үзнэ үү, Нэмэлт No.53 болон засвар (A/67/53 ба зас.1), бүлэг. IV, хэсэг. А.*

⁷ Мөн тэнд., *Нэмэлт No. 53A (A/67/53/Нэм.1), бүлэг. III.*



дэлхийн хөтөлбөрийн тухай 24/15 тоот тогтоол,⁸ 2013 оны 9 дүгээр сарын 26-ны өдрийн сэтгүүлчдийн аюулгүй байдлын талаарх хэлэлцүүлгээс гарсан Зөвлөлийн шийдвэр,⁹ 2006 оны 12 дугаар сарын 23-ны өдрийн Аюулгүйн зөвлөлийн 1738 (2006) тоот тогтоолыг мөн тус тус *эргэн санаж*,

НҮБ-ын Үзэл бодлын эрх чөлөөний асуудлаарх Тусгай илтгэгч¹⁰ болон НҮБ-ын Хууль бусаар, дур мэдэн, олноор цаазаар авах асуудлаарх Тусгай илтгэгчийн¹¹ Хүний эрхийн зөвлөлийн 20 дугаар чуулганы үеэр өргөн мэдүүлсэн тайланг *цохон тэмдэглэж*,

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн Дээд комиссарын газар болон Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагын сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хамгаалах, тэдний эсрэг гэмт үйлдэл ял шийтгэлгүй үлдэж буйтай тэмцэхэд чиглэсэн үйл ажиллагаа, чиг үүргийг *сайшаан дэмжиж*,

Нэгдсэн Үндэстний Байгууллагын Хүний эрхийн Дээд комиссарын газрын Хүний эрхийн зөвлөлийн 24 дүгээр чуулганы үеэр өргөн мэдүүлсэн сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хамгаалах сайн туршлагын тайланг¹² *талархалтайгаар онцлон тэмдэглэж*,

2013 оны 4 дүгээр сарын 23, 24-ний өдрүүдэд Варшав хотноо зохион байгуулагдсан сэтгүүлчдийн аюулгүй байдлын асуудлаарх олон улсын бага хурал, түүнээс гарсан тусгай зөвлөмжүүдийг¹³ *талархан тэмдэглэж*,

Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 19 дүгээр зүйлийн дагуу үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөөг эдэлж, интернэтээр болон онлайн бус хэлбэрээр бүхий л төрлийн мэдээ мэдээлэл, санаа бодлыг эрж хайх, хүлээн авах, дамжуулах замаар олон нийтийн санал хэлэлцүүлэг өрнүүлэхэд өөрсдийн хувь нэмэр оруулж буй хэвлэл мэдээллийн байгууллага, хувь хүн, төрөл бүрийн байгууллагын оролцоотойгоор сэтгүүл зүй тасралтгүй хөгжиж буйг *хүлээн зөвшөөрч*,

Мэдлэг бүхий нийгэм, ардчиллын бүтээн байгуулалт, соёл хоорондын яриа хэлэлцээ, энх тайван, сайн засаглалыг хөхиүлэн дэмжихэд үзэл бодлоо илэрхийлэх эрх чөлөө болоод чөлөөт хэвлэлийн оруулах бодит хувь нэмрийг *хүлээн зөвшөөрч*,

Сэтгүүлчдийн эрхэлж буй ажлын онцлог тэднийг ихэнх тохиолдолд сүрдүүлэг заналхийлэл, дарамт шахалт, хүчирхийлэлд өртөх онцгой эрсдэлд оруулдагийг *мөн хүлээн зөвшөөрч*,

Сэтгүүлчдийг хамгаалахын тулд хэрэгжүүлж буй янз бүрийн үр дүнтэй арга, түүнчлэн, шаардлагатай тохиолдолд сэтгүүлчдийн эрхийн төлөө тэмцэхүйц хүний эрхийн хамгаалагчдыг хамгаалахад чиглэсэн арга хэмжээг *онцлон дурдаж*,

⁸ Мөн тэнд., 68 дугаар чуулган, *Нэмэлт No. 53A* (A/68/53/Нэм.1), Бүлэг. III.

⁹ Мөн тэнд., 68 дугаар чуулган, *Нэмэлт No. 53A* (A/68/53/Нэм.1), Бүлэг. III.

¹⁰ A/HRC/20/17.

¹¹ A/HRC/20/22 ба Зас.1.

¹² A/HRC/24/23.

¹³ S/2013/422, хавсралтыг үзнэ үү.

Мэдээлэл толилуулагдаж буй байдлаас хэсэг бүлэг хүмүүсийн амьдрал шалтгаалдаг, мөн сэтгүүл зүй нь олон нийтийн санаа бодолд нөлөөлдөгийг *хүлээн зөвшөөрч*,

Сэтгүүлчдийн эсрэг гэмт үйлдэл ял шийтгэлгүй үлдэх нь тэднийг хамгаалах үйл ажиллагааг бэхжүүлэхэд тулгамдаж буй гол асуудлын нэгд тооцогдож буйг *анхааралдаа авч*,

Зэвсэгт мөргөлдөөн бүхий бүс нутагт мэргэжлийн аюултай үйл ажиллагаа явуулж буй сэтгүүлч, хэвлэл мэдээллийн болон холбогдох ажилтнууд жирийн иргэнд тооцогдох, жирийн иргэний статусд харшлах үйлдэл хийгээгүй нөхцөлд эдгээр хүмүүсийн нэгэн адил хүндлэгдэн, хамгаалуулах ёстойг *эргэн санаж*,

Харьяалалгүй этгээдүүд, тэр дундаа террорист болон гэмт хэргийн бүлэглэлийн сэтгүүлчдийн аюулгүй байдалд учруулж буй заналхийлэлд *түгшиж байгаагаа илэрхийлж*;

Эмэгтэй сэтгүүлчид ажил үүргээ гүйцэтгэхдээ учирч буй онцгой эрсдэлийг *хүлээн зөвшөөрч*, үүнтэй холбогдуулж сэтгүүлчдийн аюулгүй байдалд анхаарал хандуулсан арга хэмжээг шийдвэрлэхдээ жендэрийн мэдрэмжтэй хандахын ач холбогдлыг *цохон тэмдэглэж*,

1. НҮБ-ын Сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хамгаалах, тэдний эсрэг гэмт үйлдэл ял шийтгэлгүй үлдэж буй асуудлаарх үйл ажиллагааны төлөвлөгөөг *талархан тэмдэглэж байна*.

2. Эрүүдэн шүүх, хууль бусаар цаазлах, хүчээр сураггүй алга болгох, дур мэдэн баривчлах, мөн зөрчил мөргөлдөөнт, амар тайван нөхцлийн аль алинд буй айлган сүрдүүлэг, дарамт шахалт зэрэг сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтнуудын эсрэг үйлдэгдэж буй халдлага, хүчирхийллийн бүх хэлбэрийг *эрс буруушааж байна*.

3. Арваннэгдүгээр сарын 2-ны өдрийг Сэтгүүлчдийн эсрэг гэмт үйлдэл ял шийтгэлгүй үлдэж буйг таслан зогсоох олон улсын өдөр болгохыг *шийдвэрлэж байна*.

4. Нэгдсэн Үндэстний Байгууллагын Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллагад НҮБ-ын системийн холбогдох байгууллагуудтай зөвлөлдөж, Эдийн засаг, нийгмийн зөвлөлийн 1980 оны 7 дугаар сарын 25-ны өдрийн 1980/67 тоот тогтоолын хавсралтын заалтуудыг анхааралдаа авч, уг Олон улсын өдрийг засгийн газар, холбогдох талуудтай хамтран хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх *хүсэлт тавьж байна*.

5. Сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтнуудын эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, тэдний эсрэг үйлдэгдсэн сэжиг бүхий бүх хэлбэрийн хүчирхийллийн хэргийг шүүх эрх мэдлийн хүрээнд үнэн шударга, түргэн шуурхай, үр дүнтэй мөрдөн шалгах, эдгээр төрлийн гэмт хэрэг үйлдэгчдэд хариуцлага хүлээлгэх, хохирогчдыг шүүхээр хамгаалуулах эрхээр хангах асуудалд хариуцлагатай хандах талаар боломжтой бүхнээ хийхийг Гишүүн орнуудаасаа *шаардаж байна*.

6. Улс орнуудыг (а) эрх зүйн хэм хэмжээ, (б) шүүх, хууль сахиулах байгууллагын ажилтан, цэрэг, цагдаагийн бие бүрэлдэхүүн, түүнчлэн сэтгүүлчид, иргэний нийгмийн байгууллагынханд сэтгүүлчдийн аюулгүй байдалтай холбоотой олон улсын хүний эрхийн хууль тогтоомж, олон улсын хүмүүнлэгийн эрх зүйн дагуу хүлээсэн үүрэг, амлалтын талаарх ойлголт мэдлэг дээшлүүлэх, (в) сэтгүүлчдэд халдсан хэргийг хянан шинжилж, мэдээлэх, (г) халдлагын хэргийг нийтээр буруушаах болон (д) эдгээр төрлийн халдлагыг

мөрдөн шалгаж, шийтгэл ногдуулахад шаардлагатай нөөц бололцоог зориулах замаар сэтгүүлчдэд ажил үүргээ бие даан, хөндлөнгийн оролцоогүйгээр гүйцэтгэхэд нь аюулгүй, таатай орчин бүрдүүлэхийг *уриалж байна*.

7. Сэтгүүлчдийн аюулгүй байдлыг хамгаалах, тэдний эсрэг гэмт үйлдэл ял шийтгэлгүй үлдэж буй асуудлаарх НҮБ-ын үйл ажиллагааны төлөвлөгөөг Нэгдсэн Үндэстний Боловсрол, шинжлэх ухаан, соёлын байгууллага Гишүүн орнуудтай хамтран зохион байгуулж хэрэгжилтийн талаар мэдээлэл солилцох зорилгоор мэдээллийн төв байгуулах *саналыг* НҮБ-ын системийн холбогдох агентлаг, байгууллага, сан, хөтөлбөрт *гаргаж байна*.

8. Уг тогтоолын хэрэгжилтийн талаар Ерөнхий Захиралд Ерөнхий Ассамблейн 69 дүгээр чуулганы үеэр тайлагнах *хүсэлт тавьж байна*.

*Далдугаар нэгдсэн хуралдаан
2013 оны 12 дугаар сарын 18-ны өдөр*